

ТАНИЛЦУУЛГА

“Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай” Улсын
Их Хурлын тогтоолын төслийн танилцуулга

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 385 дугаар тогтоолоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-д онцгой дэглэм тогтоож, тус компанид Засгийн газрын Онцгой бүрэн эрхт төлөөлөгчийг томилон ажиллуулж байгаа билээ.

Онцгой дэглэм тогтоох үед “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн санхүү, төсвийн нөхцөл байдал хүндрэлтэй, сахилга бат сайнгүй байсан бөгөөд үйл ажиллагаа ил тод бус, хэрэгжүүлж буй томоохон төсөл хөтөлбөртэй холбоотой мэдээлэл нууцад хамрагдсан, ажлын гүйцэтгэл хоцрогдолтой байсан. Тодруулбал, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн худалдан авагчдад төлөх өр төлбөр 582 сая ам.доллар, бонд болон бусад урт хугацаат өр төлбөр 450 сая ам.доллар, гэрээт олборлогчдод төлөх өр төлбөр 123 тэрбум төгрөг байсан бөгөөд нийт 1.7 их наяд төгрөгийн мөнгөн хөрөнгийн дутагдалтай төсвийг Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулаад байсан.

“Эрдэнэс Таван толгой” ХК-ийн нийт ажиллагсдын дунд удирдах албан тушаалтны эзлэх хувь өндөр, ажлын байрны чиг үүргийн давхардал их, зохион байгуулалтын бүтэц оновчгүй байсан бөгөөд ажилчдын сахилга хариуцлагыг сайжруулах шаардлагатай байсан болно.

“Эрдэнэс Таван толгой” ХК-ийн Онцгой бүрэн эрхт төлөөлөгч Засгийн газрын 2022 оны 362, 385 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд нүүрс олборлолт, тээвэрлэлтийг оновчтой зохион байгуулах, борлуулалт, экспортыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны нээлттэй ил тод байдлыг хангах, нүүрсийг хил нөхцөлөөр биржээр арилжих, шаардлагатай төсөл хөтөлбөрийг эрэмбэлэн хэрэгжүүлэх чиглэлээр дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлээд байна. Үүнд:

- 1. Нүүрсийг биржээр, хил нөхцөлөөр борлуулж, нүүрсний үнэ, борлуулалтыг нэмэгдүүлсэн.** Монголын хөрөнгийн биржээр дамжуулан нүүрсний нээлттэй цахим арилжааг 2023 оны 2 дугаар сарын 9-ний өдөр анх удаа зохион байгуулсан ба нийт 7 удаагийн арилжаагаар 416 мянган тонн нүүрсийг 53.9 сая ам.доллараар борлуулж, 20.9 сая ам.долларын нэмэлт орлого олсон. Биржийн арилжаагаар 224 мянган тонн коксжих нүүрс, 192 мянган тонн эрчим хүчний нүүрсийг Ганцмод нөхцөлөөр борлуулсан. Энэ 2023 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн цахим арилжаагаар эрчим хүчний нүүрсний арилжааг анх удаа амжилттай зохион байгуулж, 96 мянган тонн эрчим хүчний нүүрсийг биржээр борлуулсан. Нүүрсийг хил нөхцөлөөр, биржээр борлуулснаар коксжих нүүрсний үнэ тонн тутамд 100-115 ам.доллар байсныг 178.6-182.1 ам.долларт, эрчим хүчний нүүрсний үнэ тутамд 37 ам.доллар байсныг 70.3-73.3 ам.долларт хүрсэн болно;
- 2. Нүүрс тээврийн зохион байгуулалтыг сайжруулж, тээврийн компаниудын үйл ажиллагааг дэмжсэнээр, тэдний төсөвт төлөх татварын хэмжээ нэмэгдсэн.** Нүүрсийг биржээр, хил нөхцөлөөр борлуулахад шаардлагатай тээврийн тендерийг “Ерөнхий гэрээний журам”-ын дагуу зарлаж, амжилттай зохион байгуулав. Тендерт 218 аж ахуйн нэгж оролцож, 377 санал ирүүлснээс

шаардлага хангасан 176 санал ирүүлсэн 122 аж ахуйн нэгжтэй ерөнхий гэрээ байгуулсан. Хоёр дахь шатны тендер шалгаруулалтаар 2 чиглэлд 4 багцад 12 компанийг шалгаруулж, нийт 288 мянган тонн нүүрс нийлүүлэх гэрээг 2023 оны 3 дугаар сарын 3-ны өдрөөс эхлүүлж, 96 мянган тонн нүүрсийг хүргэж өгөөд байна. Энэхүү үйл ажиллагаанаас 6.4 тэрбум төгрөгийн тээврийн зардлын хэмнэлт хийгээд байна.

Засгийн газрын 2022 оны 362 дугаар тогтоолын дагуу хил нэвтрэх С зөвшөөрөл олголтыг олон нийтэд нээлттэй, ил тод байдлаар зохион байгуулж, мэдээллийг компанийн цахим хуудаст байршуулсан. Ингэснээр 2023 оны 3 дугаар сарын 3-ны өдрөөс биржийн нүүрс тээврийг эхлүүлж, Ганцмод боомт дахь худалдан авагчийн нэрлэсэн талбайд хүргэж өгсөн;

3. **“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн тусгай зөвшөөрлийн талбайгаас нүүрс дутсан асуудлыг эцэслэн шийдвэрлэв.** “Тавантолгой” ХК нь “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн тусгай зөвшөөрөлтэй талбайд нэвтэрч олборлолт хийсэн асуудал эцэслэн шийдвэрлэгдээгүй байсан. Өнгөрсөн 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдөр “Тавантолгой” ХК-иас 258.9 мянган тонн нүүрсний төлбөр болох нийт 13.9 сая доллар буюу 48 тэрбум төгрөгийг “Эрдэнэс тавантолгой” ХК-д шилжүүлж, төлбөрийг бүрэн төлж барагдуулсан;

4. **Нүүрс худалдах, худалдан авах гэрээний нөхцөлийг өөрчлөн, уурхайн ам.нөхцөлөөс, хил нөхцөлд шилжүүлэв.** Онцгой дэглэм тогтоох үед “Эрдэнэс Тавантолгой” ХК нь нийт 178 нүүрс худалдах, худалдан авах гэрээтэй байсан бөгөөд үүнээс уурхайн ам нөхцөлтэй 133 гэрээ, FCA-Гашуунсухайт нөхцөлтэй 7, оффтэйк 4 гэрээтэй холбоотой 38 дэд гэрээ байсан. Оффтэйк 4 гэрээтэй холбоотой 38 дэд гэрээний хувьд “Тавантолгой-Гашуунсухайт” чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалттай холбоотой 27 гэрээ, “Богдхан” төмөр замын бүтээн байгуулалттай холбоотой нь 9 гэрээ, нүүрс баяжуулах үйлдвэрийн болон газрын тос дамжуулах хоолойн бүтээн байгуулалттай холбоотой тус бүр 1 гэрээ байсан.

Онцгой дэглэмийн хугацаанд гэрээний нөхцөлийг сайжруулах чиглэлээр худалдан авагчидтай хэлэлцээр хийх ажлыг тогтмол зохион байгуулав. Улмаар 2023 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар “Эрдэнэс Тавантолгой” ХК нь нийт 101 нүүрс худалдах, худалдан авах гэрээтэй байгаагаас DAP-Ганцмод нөхцөлтэй 87 гэрээ, уурхайн ам нөхцөлтэй 11 гэрээ, оффтэйк гэрээтэй холбоотой 3 гэрээ байна. “Тавантолгой-Гашуунсухайт” төмөр замын бүтээн байгуулалттай холбоотой 27 гэрээнээс 26 гэрээг дуусгавар болгосон бөгөөд үлдсэн 1 худалдан авагчтай байгуулсан гэрээний үлдэгдэл 4.3 сая тонн байна. Энэ нь нүүрсээр төлөх санхүүжилтийг хийхэд хангалттай болно. Түүнчлэн, Богдхан төслийн бүтээн байгуулалтыг зогсоосон тул түүнд хамаарах 9 гэрээг дуусгавар болгосон;

5. **Уулын ажил гүйцэтгэх зардлыг бууруулав.** “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн уулын ажлын гэрээт гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалтыг амжилттай зохион байгуулав. Энэ үйл ажиллагааны үр дүнд нэг м3 уулын ажлын зардлыг 12,945 төгрөг байсныг 1,445 төгрөгөөр бууруулан 11,500 төгрөг, нэг м3 өрөмдлөг тэсэлгээний ажлын зардлыг 2,000 төгрөг байсныг 110 төгрөгөөр бууруулан 1,890 төгрөг, нэг тонн нүүрс ачилтын зардлыг 1,763 төгрөг байсныг 118

төгрөгөөр бууруулан 1,645 төгрөг болгож, нийт 254.9 тэрбум төгрөгийн зардлын хэмнэлт хийх нөхцөл бүрдүүлэв;

6. **Компанийн өр төлбөрийг барагдуулж, ашигт ажиллагааг нэмэгдүүлэв.** Дээр дурдсан онцгой дэглэм тогтох үеийн санхүүгийн үзүүлэлтийг эрс сайжруулж, худалдан авагчдад өгөх өр төлбөр 582 сая ам доллар байсныг 286.4 сая ам.доллар болгон бууруулж, ЭТТ-Бондын 2023 оны эхний төлбөр 236.5 тэрбум төгрөг, 39.0 сая ам.долларыг төлж барагдуулав. Үүгээр зогсохгүй, 1.7 их наяд төгрөгийн мөнгөн хөрөнгийн дутагдалтай байхаар баталсан төсвийг сайжруулж, 385 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгийн эерэг үлдэгдэлтэй гаргасан. Өмнөх 2021 оны 9 дүгээр сараас хойш хуримтлагдсан туслан гүйцэтгэгч компаниудад төлөх 123 тэрбум төгрөгийн өр төлбөрийг 2 сарын дотор төлж барагдуулав.
7. **Ил тод байдлыг хангах үүднээс нууцад хамруулсан төслийн гэрээнүүдийг ил тод болгов.** Монгол Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 449 дүгээр тогтоолын дагуу “Эрдэнэс Тавантолгой” ХК-д холбогдох төрийн нууцын зэрэглэлтэй 7 гэрээг нууцаас гаргасан. Улмаар, “Тавантолгой-Гашуунсухайт” чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалттай холбоотой 2 гэрээ, “Богдхан” төмөр замын бүтээн байгуулалттай холбоотой 3 гэрээ, Загийн усны хоолойн болон далд уурхайн бүтээн байгуулалттай холбоотой тус бүр 1 гэрээг нууцаас гарган, компанийн цахим хуудсаар дамжуулан олон нийт нээлттэй танилцах боломжоор хангасан;
8. **Уурхайн хүчин чадлыг өсгөх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг бий болгох, өртөг, зардлыг бууруулах төслүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх бодлого баримтлан ажиллав.** “Эрдэнэс Тавантолгой” ХК нь үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор уурхайн тоног төхөөрөмжийн шинэчлэл, уурхайн конвейрийн бүтээн байгуулалтын 2 төсөл, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор нүүрс баяжуулах үйлдвэр, усан хангамж, газрын тос дамжуулах хоолой, цахилгаан станцын 4 төсөл, төмөр замын 5 төсөл, нийт 11 төслийг хэрэгжүүлж байна. Эдгээр төслийн нийт төсөвт өртөг 4.9 тэрбум ам.доллар бөгөөд одоогийн байдлаар 1.5 тэрбум ам.долларын санхүүжилт олгоод байна.

Хэрэгжүүлж буй төслүүдээс “Богдхан” төмөр замын төслийг зогсоосон бөгөөд бусад төслийн санхүүжилтийг төслийн ач холбогдол, компанийн санхүүгийн нөхцөл байдалтай уялдуулан санхүүжүүлж байна. Төмөр замын төслүүд гэрээнд заасан хугацаанаас хоцрогдолтой байгаа тул эдгээр төслийг эрчимжүүлэх, шуурхай дуусгахад анхаарч ажиллаж байна. Түүнчлэн, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор баяжуулах үйлдвэрийн төсөл, түүнтэй холбоотой конвейр нэвтрүүлэх төслийг ойрын хугацаанд дуусгахаар төлөвлөж байгаа болно.

Баяжуулах үйлдвэрийн төслийг богино хугацаанд амжилттай хэрэгжүүлснээр ордын нөөцийг бүрэн ашиглах, уурхайн насжилтыг уртасгах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг бий болгох онцгой ач холбогдолтой. Уг үйлдвэр ашиглалтад орсноор олборлосон бүх нүүрсээ борлуулах, уурхайн ашиглалтын нөхцөл сайжрах, сорчлон олборлохоос сэргийлээд зогсохгүй олборлож борлуулах нүүрсний үнийг 10%-30% буюу тонн тутамд 60-80

ам.доллороор нэмэгдүүлэх боломжтой. Баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалттай зэрэгцэн тус үйлдвэрийг түүхий эдээр хангах конвейерийн төсөл, усаар хангах Загийн усны хоолойн төсөл, эрчим хүчээр хангах Тавантолгой цахилгаан станцын төслийг эрчимжүүлэх шаардлагатай байна. Тухайлбал, конвейерийн төслийг хэрэгжүүлснээр тээврийн зардал хэмнэх, тоосжилт буурах, аюулгүй ажиллагаа сайжрах, нүүрс экспортын замын ачаалал бууруулаад зогсохгүй баяжуулах үйлдвэрийн тасралтгүй, найдвартай үйл ажиллагааг хангана;

9. **Компанийн бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгох ажлын хүрээнд шаардлагагүй алба нэгжийг татан буулгаж, удирдах ажилтны тоог бууруулж, 2022 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг давуулан биелүүлэн нийт ажилтнуудад цалин, урамшууллыг олгов.** Онцгой дэглэмийн хугацаанд эрхэлсэн ажилдаа хариуцлагагүй хандсан 20, ажлын цагийн бүртгэл, тайлагналт, хяналтгүй ажиллаж байсан 13, нийт 33 ажилтныг үүрэгт ажлаас чөлөөлсөн. Түүнчлэн, чиг үүрэг давхардсан, үргүй зардал гаргах нөхцөл бүрдүүлсэн, шинээр баталсан нийт 12 алба, 1 нэгж, 1 төвийг татан буулгасан бөгөөд үүнтэй холбоотойгоор 26 ажилтныг чөлөөлсөн. Улмаар, компанийн төв оффисын удирдах ажилтны тоо нийт ажилчдын 25%-иас 16% болж буурав;
10. **Хууль зөрчсөн байж болзошгүй тохиолдлуудыг хяналт, шалгалтын байгууллагад гомдол гарган шилжүүлсэн.** Төлбөрийн баталгаагүйгээр мөнгө шилжүүлэх оролдлого хийсэн, тендерт шалгарсан компанитай шалтгаангүйгээр гэрээ байгуулаагүй, албан ёсны гэрээгүйгээр ажил гүйцэтгүүлсэн, компанид мэдэгдэлгүй тусгай зөвшөөрөлтэй талбайд газар олгосон, талбайгаас нүүрс дутсан зэрэг 9 албан хаагч, 6 хуулийн этгээдэд хамаарах 15 өргөдөл гомдлыг Авлигатай тэмцэх газарт, 5 гомдлыг Эрүүгийн цагдаагийн газарт хүргүүлсэн.
11. “Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 457 дугаар тогтоолоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн үйл ажиллагаанд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудит хийлгэхээр шийдвэрлэсний дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5 дахь заалтын дагуу тендер шалгаруулалтын онцгой журам гэрээ шууд байгуулах аргаар 3 удаа зохион байгуулан олон улсад нэр хүнд бүхий аудитын компаниудад тухай бүр урилга хүргүүлж, 2 удаа уулзалт зохион байгуулсан боловч оролцогч материал ирүүлэгүй тул хуулийн 34.2-т заасны дагуу хэлэлцээр хийж байна. Хэлэлцээрийн шатанд нэр бүхий олон улсад эрхтэй аудитын компанитай хамтран ажиллах саналаа хүргүүлэн урьдчилсан уулзалтыг хийсэн бөгөөд одоогоор тус компанийн эрсдлийг үнэлэх баг ажиллаж байна.

Онцгой дэглэмийн хугацаанд олборлолт, тээвэрлэлтийг оновчтой зохион байгуулах, борлуулалт, экспортыг нэмэгдүүлэх, нээлттэй, ил тод байдлыг хангах, нүүрсийг хил нөхцөлөөр, биржээр арилжих зэрэг дээр дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлснээр дараахь эерэг үр дүнд хүрээд байна:

1. Онцгой дэглэм тогтоосон 2022 оны 10 сарын 26-ны өдрөөс хойш 5 сарын хугацаанд 1,260.6 сая ам.долларын үнэлгээ бүхий 13.0 сая тонн нүүрс борлуулсан. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн борлуулалтын орлого 2022 онд 1.1 тэрбум ам.доллар буюу компани үүсгэн байгуулагдсан цагаас хойш хамгийн

өндөр түвшинд хүрсэн ба онцгой дэглэм тогтоосон 5 сарын хугацаанд борлуулалтын орлого 2022 оны жилийн дүнгээс давсан байна;

2. Онцгой дэглэмийн хугацааны сарын дундаж үйлдвэрлэл, эдийн засгийн үзүүлэлт түүний өмнөх үетэй харьцуулахад эрс сайжирсан. Тухайлбал, борлуулсан нүүрсний хэмжээ 4.1 дахин, тээвэр 3.9 дахин, экспорт 2 дахин, орлого 3.9 дахин, олборлолт 2.7 дахин тус тус өссөн;
3. Засгийн газрын 2022 оны 362 дугаар тогтоолын дагуу 500 сая ам.доллараас багагүй орлого олох үүргийг давуулан биелүүлж, 588 сая ам.долларын орлого олж, 416.6 сая ам.долларыг Монголбанканд тушаасан;
4. Өнгөрсөн 2022 онд компанийн түүхэн дэх хамгийн өндөр орлого, ашигтай ажилласан жил болж, төсөвлөсөн цэвэр ашгийг 56%-р давуулан биелүүлж, цэвэр ашиг 1.3 их наяд төгрөгт хүрэв;
5. Энэ оны эхнээс 3 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл 765.2 сая ам долларын үнэлгээтэй 7.5 сая тонн нүүрс борлуулсан ба үүнээс 445.6 сая ам.долларыг дансанд төвлөрүүлж, “ЭТТ-БОНД”-ын 120 орчим сая ам.долларын үндсэн болон хүүгийн эргэн төлөлтийг үндсэн үйл ажиллагааны орлогоор төлөх боломжийг бүрдүүлэн худалдан авагчдад төлөх өр төлбөрийг 169.2 сая ам.доллараар бууруулж, 284.6 сая ам.доллар болгов;
6. Нийт 7 удаагийн биржийн арилжааг амжилттай зохион байгуулж, 224 мянган тонн коксжих нүүрс, 192 мянган тонн эрчим хүчний нүүрс, нийт 416 мянган тонн нүүрсийг биржээр, хил нөхцөлөөр амжилттай борлуулсан;
7. нүүрс олборлохоос экспортлох үе шатыг ил тод болгон төсөвт төвлөрүүлэх татвар, хураамжийн төлөвлөгөөг 1.6 дахин буюу 470.5 орчим тэрбум төгрөгөөр давуулав;
8. Тээврийн үйл ажиллагааны тендерийг амжилттай зохион байгуулж, С зөвшөөрөл олгох үйл ажиллагааг нээлттэй ил тод болгож, нүүрсийг хил хүртэл тээвэрлэх, борлуулах бэлтгэл хангагдав. Биржээр борлуулсан нүүрсийг 2023 оны 3 дугаар сарын 3-ны өдрөөс Ганцмод боомтод хүргэж эхлэв.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-д онцгой дэглэм тогтоосон хугацаанд санхүүгийн нөхцөл байдал сайжирч, гадаад валютын орох урсгал нэмэгдсэн хэдий ч дээрх хүрээд буй үр дүнг тогтвортой хадгалах, цаашид улам сайжруулан “Эрдэнэс Тавантолгой” ХК-г олон улсын жишигт нийцсэн компани болгох зорилгоор дараахь арга хэмжээг зайлшгүй авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

1.Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нэр хүндтэй хөндлөнгийн аудитын байгууллагаар аудит хийлгэх.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн засаглалыг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэх зорилгоор Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 457 дугаар тогтоолоор олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, хөндлөнгийн хараат бус аудитын байгууллагаар компанийн үндсэн үйл ажиллагаа болох уул уурхайн бүх шатны үйл ажиллагаа, санхүүгийн бүртгэл, тайлагнал,

хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрт аудит хийлгэж, тайлан, дүгнэлтийг гаргуулах арга хэмжээг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу тендер шалгаруулалтын онцгой журам хэрэглэж, гэрээ шууд байгуулах аргаар тендер шалгаруулалтыг 3 удаа зохион байгуулан олон улсад нэр хүнд бүхий аудитын компаниудад тухай бүр урилга хүргүүлж, уулзалт зохион байгуулсан бөгөөд санхүүгийн өр төлбөрийн асуудлаас шалтгаалан оролцогч материал ирүүлээгүй тул хуульд заасны дагуу хэлэлцээ хийх арга хэмжээ авч, хэлэлцээний шатанд нэр бүхий олон улсад эрхтэй аудитын компанитай хамтран ажиллах саналаа хүргүүлэн урьдчилсан уулзалтыг хийж, үүсэх эрсдлийг үнэлэх арга хэмжээ хийгдэж байна.

Иймд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн засаглалыг сайжруулах, үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх нөхцөл бололцоог хангуулах зорилгоор дээрх аудитын дүгнэлтэд үндэслэн “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн засаглалыг сайжруулах, үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэх арга хэмжээ авах үүднээс “Эрдэнэс Тавантолгой” ХК-д тогтоосон онцгой дэглэмийн хугацааг сунгах нь зүйтэй байна.

2.Нүүрсийг биржээр, хил нөхцөлөөр борлуулах үйл ажиллагааг жигдрүүлэх.

Монгол Улсын Их Хурлаас 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр баталсан Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр хуульчилсан. Засгийн газрын 2022 оны 466 дугаар тогтоолоор баталсан “Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны журам”-ын дагуу “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн экспортод гаргах нүүрсийг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан амжилттай, үр дүнтэй хэрэгжүүлж байна.

Иймд нүүрсний нээлттэй цахим биржийн арилжааг үргэлжлүүлэн тогтвортой явуулах, жигдрүүлэх, дээрх хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл арга хэмжээг хангуулах үүднээс “Эрдэнэс Тавантолгой” ХК-д тогтоосон онцгой дэглэмийн хугацааг сунгах шаардлагатай болоод байна.

3.Компанийн засаглал, бүтэц, менежментийг сайжруулах, оновчтой болгох.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын Төрийн бүтээмжийн сэргэлтийн хүрээнд “Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашиг, засаглалыг сайжруулж, олон нийтийн шууд хяналтад оруулах ажлыг зохион байгуулна.” гэж заасны дагуу Засгийн газрын 2023 оны 84, 85 дугаар тогтоолоор “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”, “Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах нийтлэг журам”, Төрийн өмчит, төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн ажлын байрны сул орон тоонд нээлттэй сонгон шалгаруулалт явуулах нийтлэг журам”-ыг тус тус батлан мөрдүүлж, төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг сайжруулах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж эхлээд байна.

Энэ хүрээнд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн удирдлага, бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тогтоож, мэргэжлийн чадварлаг хүний нөөцөөр бүрдүүлэх асуудлыг нээлттэй сонгон шалгаруулалтын зарчмаар шийдвэрлэж ажиллах болно.

Улсын Их Хурлын Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2023 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанаар “Эрдэнэс Таван толгой” ХК-д тогтоосон онцгой дэглэмийн үед тодорхой үр дүн гарч эхэлснийг тэмдэглээд онцгой дэглэмийн хугацааг сунгах, Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгчийг үргэлжлүүлэн ажиллуулах нь зүйтэй гэж дүгнэн Засгийн газраас холбогдох шийдвэрийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэсэн чиглэлийг ирүүлсэн байна.

Иймд дээр дурдсан үндэслэл, шаардлагын дагуу “Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, “Эрдэнэс Тавантолгой” ХК-д тогтоосон онцгой дэглэмийн хугацааг 6 сараар сунгах, уг онцгой дэглэмийн хугацаанд холбогдох хуульд заасан асуудлын хүрээнд шаардлагатай арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх болон тогтоолын хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, дагаж мөрдөх хугацааг тусгасан болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР